



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 109, 110 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Капитал банкин дахь нийт 4,087,365,030.28 нийт (дөрвөн тэрбум наян долоон сая гурван зуун жаран таван мянга гучин төгрөг хорин найман мөнгө) төгрөгийн хугацаатай мөнгөн хадгаламжийн авлагад тооцон тус банкны эрх хүлээн авагчаас санал болгож хүлээн авахаар тохиролцсон 3,987,357,993.42 (гурван тэрбум есөн зуун наян долоон сая гурван зуун тавин долоон мянга есөн зуун ерэн гурван төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн үнэлгээ бүхий нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, 4 дүгээр хороолол /16061/ Хасбаатар гудамж, 46 тоот хаягт байршилтай 1560 м.кв талбай бүхий эмнэлгийн зориулалтын 1-4 давхар барилгыг , 390 м.кв талбай бүхий зоорийн давхрын хамт тус сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирал Н.Хүрэлбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Эмнэлгийн барилгыг Капитал банкны эрх хүлээн авагчаас хүлээлгэн өгсөн хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтаар шилжүүлэн авах;

2.2. “Капитал банк” ХХК-ийн нэр дээр байгаа үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг улсын бүртгэлээс хасуулж Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нэр дээр шилжүүлэн баталгаажуулах ажлыг эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

2.3. Эмнэлгийн барилгын доорх Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хороо Хувьсгалчдын Д-0 гудамж, 11 тоот хаягт байршилтай нэгж талбарын 1860312963119 дугаартай 700 м.кв талбайтай газар, мөн хаягт байршилтай нэгж талбарын 1840312968103 дугаартай 181 м.кв талбайтай газрын эрхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн нэр дээр баталгаажуулах асуудлыг эрх бүхий байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх;

13201837

2.4. Газар эзэмших эрхийг баталгаажуулсны үндсэн дээр газар эзэмших эрхийн үнэлгээг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн данс бүртгэлд “биет бус хөрөнгө”-өөр бүртгэх;

2.5.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.6. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ